



ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

Б. Оюуншар  
санзурга.

төрийн

2022 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/125

Зуунмод сум

“Монгол цэргийн өдөр” Зэвсэгт хүчний  
101 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 65 дугаар зүйлийн 65.1.1, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Монгол цэргийн өдөр” Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 101 жилийн ойг угтан орон нутагт Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах, ахмад дайчдын алдар гавьяаг алдаршуулах, иргэд хүүхэд залуучуудад цэрэг эх оронч хүмүүжил төлөвшүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын уялдааг нэмэгдүүлэх зорилгоор 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрөөс 18-ны өдрүүдэд тусгай төлөвлөгөөний дагуу ойн арга хэмжээ зохион тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2. Баярын арга хэмжээнд шаардагдах төсвийг нэг, хоёр, гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Монгол Улсад орчин цагийн зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 101 жилийн ой, Монгол цэргийн өдрийн баярыг угтаж Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудтай хамтран аймгийн Засаг даргын нэрэмжит цэрэгжилтийн болон спортын олон төрөлтийн тэмцээнийг зохион байгуулах, ард иргэд хүүхэд залуучуудад сурталчлаж, төлөвлөгөөний дагуу зохион явуулахыг Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга (дэд хурандаа Т.Төмөрчөдөр)-д үүрэг болгосугай.

4. “Монгол цэргийн өдөр” Зэвсэгт хүчний 101 жилийн ойн баярын нэгдсэн арга хэмжээг 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдөр аймгийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын нэгдсэн баярын ёслолын жагсаалыг Мөнх-Алдарын талбайд зохион байгуулж явуулахыг Их булаг цэргийн хүрээ Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн захирагч (Бригадын генерал Т.Лодойдамба)-д зөвшөөрсүгэй.

5. Баярын хүндэтгэлийн тоглолтыг төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудтай хамтран зохион явуулахыг Монгол туургатан театрын захирал (Д.Намсрайноров), Цэргийн штабын дарга (Дэд хурандаа Т.Төмөрчөдөр)-д нарт үүрэг болгосугай.

6. Арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлсэн тайлан, мэдээг Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлэхийг Цэргийн штабын дарга (Дэд хурандаа Т.Төмөрчөдөр)-д хариуцуулсугай.

7. Үйл ажиллагаанд шаардагдах 3,856,500 (гурван сая найман зуун тавин зургаан мянга таван зуу) төгрөгийг аймгийн хуваарилагдаагүй зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т, шилэн дансанд байршуулахыг төсвийн ерөнхий нягтлан бодогч (Б.Одончимэг) нарт тус тус зөвшөөрсүгэй.



ЗАСАГ ДАРГА *Мөнхбаатар* Д.МӨНХБААТАР

Аймгийн Засаг даргын 2022 оны 03 -р сарын 04 -ны өдрийн А/129-р захирамжийн 1 -р хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ МАРШ ТАКТИК ТУСГАЙ  
БЭЛТГЭЛИЙН АВАРГА ТАСАГ ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНД  
ЗАРЦУУЛАГДАХ ТӨСВИЙН ТООЦОО

№	Тэмцээний төрөл	Байр	Өргөмжлөл	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Мөнгөн шагнал /үнэ/	Бүгд үнэ
1.	МАРШ тактикийн аварга тасаг шалгаруулах тэмцээн	1-р байр	Өргөмжлөл	1 ш	25000	150000	175000
2.		2-р байр	Өргөмжлөл	1 ш	25000	100000	125000
3.		3-р байр	Өргөмжлөл	1 ш	25000	80000	105000
4.		Тусгай байр	Өргөмжлөл	1 ш	25000	50000	75000
5.	Алт, мөнгө, хүрэл медаль			36ш	7500	270.000	
Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 101 жилийн ойг угтсан телевизийн нэвтрүүлэг хийхэд шаардагдах төсөв.						250,000	250,000
6.	Нийт дүн=1,000,000						
Монгол цэргийн өдрийн тохиолдуулан хүндэтгэлийн хүлээн авалт							
1.	Хүний тоо			Нэг бүрийн үнэ			Бүгд үнэ
2.	60			10.000			600,000
3.	Нийлбэр дүн=1,600,000						

ТӨСӨВ ЗОХИОСОН:

АЙМГИЙН ЗДТГ-ЫН НЭРЭМЖИЙН ШТАБЫН ДАРГА  
ДЭД ХУРАНДАА Т.ТӨМӨРЧӨДӨР

ХЯНАСАН:

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ  
МЭРГЭЖИЛТЭН Ч.ЦЭЦЭГСҮРЭН

